



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 31

Номгон

**Хөрөнгөд эзэмшигч тогтоох,
хөрөнгө актлах тухай**

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын холбогдох заалт, байгууллагын хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 333 541 959 /гурван зуун гучин гурван сая таван зуун дөчин нэгэн мянга есөн зуун тавин ес/ төгрөгийн хөрөнгөөр баригдсан Эрдэнэмандал 2 дугаар багийн төвийн барилгын эзэмшигчээр аймгийн Биеийн тамир, спортын газрыг тогтоосугай.

2. Эрдэнэмандал 2 дугаар багийн төвийн барилгын ашиглалт, хамгаалалтыг сайтар хангаж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газрын даргад даалгасугай.

3. “Чандмань-Баянхонгор” ХК-ний конторын барилгыг ашиглагдах боломжгүй болсон тул акталж, данснаас хассугай.

4. Дээрх конторын барилгыг акталсантай холбогдуулан барилгыг нурааж, дараагийн төлөвлөсөн ажлыг шуурхай эхлүүлэхийг “Чандмань-Баянхонгор” ХК-д зөвшөөрсүгэй.

5. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116021